



СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРГАА ИД

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
ДҮГНЭЛТ

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 3,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 31 06 12, 7600 33-1126, Факс: (976-11) 32 29 04,

Цахим шуудан: info@mcud.gov.mn,

Цахим хуудас: www.mcud.gov.mn

2023.06.29 № 02-00-01/004/53

Барилга байгууламжийн
ашиглалтын төлөв байдлын
тухай

Барилга, хот байгуулалтын яамны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 02-00/07 дугаартай "Улсын хэмжээнд ашиглагдаж байгаа орон сууц, олон нийт, иргэний барилга байгууламж, тэдгээрийн инженерийн шугам сүлжээ, лифт, эскалаторын ашиглалт, эдэлгэний үеийн аюулгүй байдалд (газар хөдлөлтийн тэсвэржилтийн) урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай" удирдамжийн хүрээнд Баянзүрх дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэр Шар хаданд байршилтай Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 12 барилга байгууламжийн ашиглалтын төлөв байдал, барилга байгууламжийн техникийн баримт бичгийн хөтлөлт, хадгалалтанд үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэв.

Шалгалтаар Төрийн хяналт шалгалтын тухай, Хот байгуулалтын тухай, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай, Газрын тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай, Геодези, зураг зүйн тухай, Барилгын тухай, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай, Эрчим хүчний тухай, Хаягжуулалтын тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжлэлтэд үнэлэлт дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйн зөвлөгөө зөвлөмжөөр хангах зорилгоор холбогдох 6 хяналтын чиглэлийн улсын ахлах байцаагчдын бүрэлдэхүүнтэйгээр: 023 оны 04 дүгээр сарын 05, 11-ний өдрүүдэд газар дээр нь үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэн, 04 дүгээр сарын 05, 10, 11, 24-ний өдрүүдэд барилга байгууламжийн хуулийн хэрэг, техникийн баримт бичгийг судалж танилцлаа.

Шалгалтанд тус төвийн ерөнхий захирал В.Баярмаа, аж ахуйн менежер Г.Цэгмид, үндсэн хөрөнгийн нягтлан бодогч Э.Гэрэлмаа, барилгын инженер н.Гэндэн,

1523110174

сантехникийн инженер Б.Сүхбат, цахилгааны инженер Б.Пүрэвсүрэн нар байлцсан болно.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв /Шархад эмнэлэг/ нь 1929 онд 20 ортой, 1 орос эмчтэйгээр үүсгэн байгуулагдсан ба 2014 онд 450 ортой, 85 их эмчтэй, 116 сувилагчтай, нийт 497 ажилчидтай байсан бол 2023 оны байдлаар 550 ортой, 490 орчим ажиллагсадтай байна.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/261 тоот шийдвэрээр Баянзүрх дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 84535 м² газрыг эмнэлгийн зориулалтаар 15 жилийн хугацаатайгаар олгож, нэгж талбарын 1331900484 дугаар, Төрийн байгууллагын газар эзэмших 15782 дугаартай эрхийн гэрчилгээ олгосон байна.

Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайланг "Нандин байгаль" ХХК аар хийлгэсэн байна.

Нийслэлийн Засаг даргын 2016 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/519 тоот шийдвэрээр Баянзүрх дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 220 м² газрыг цэвэрлэх байгууламжийн зориулалтаар 20 жилийн хугацаатайгаар олгож, нэгж талбарын 1331900659 дугаар, Төрийн байгууллагын газар эзэмших 1794 дугаартай эрхийн гэрчилгээ олгосон байна.

Нийслэлийн Засаг даргын 2016 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/563 тоот шийдвэрээр Баянзүрх дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 481 м² газрыг Ус түгээх, шахах, өргөх байгууламж, хоолойн зориулалтаар 20 жилийн хугацаатайгаар олгож, 1331900104 нэгж талбарын дугаар, 1795 дугаартай Төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон байна.

Нийслэлийн Засаг даргын 2018 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/546 тоот шийдвэрээр Баянзүрх дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 528 м² газрыг Ус түгээх цэгийн зориулалтаар 15 жилийн хугацаатайгаар олгож, нэгж талбарын 1331902286 дугаар, Төрийн байгууллагын газар эзэмших эрхийн 1792 дугаартай гэрчилгээ олгосон байна.

Тус төвийн барилга байгууламж нь 10 блок барилга, 2 байгууламжаас бүрдэж байна. Үүнд: А блок -Төв байр, Б блок -160 ортой эмнэлгийн барилга, гал тогоо, эмийн сангийн барилга, В блок- Сэтгэц нийгмийн сэргээн засах тасгийн барилга, В блок -Асрамжийн тасгийн барилга, Г блок-220 ортой өргөтгөл барилга, уурын зуухны

барилга, соёлын танхим, агуулахын барилга, угаалгын барилга, 200 м³ багтаамжтай усан сан, бага оврын цэвэрлэх байгууламж багтаж байна.

Төвийн ус хангамжийн систем нь хүйтэн ус, хэрэгцээний халуун ус хан амж гэсэн 2 хэсгээс бүрддэг бөгөөд цэвэр ус хангамжийн 1 гүний худаг, цэвэр ус нөөцлөх усан сан, бага оврын цэвэрлэх байгууламж зэрэг инженерийн байгууламж, тоног төхөөрөмжүүдтэй. Гүний худгаас олборлосон усыг өргөх насосоор эмнэлгээс 1.5 км-ийн зайд орших ус нөөцлөх байгууламжид хуримтлуулан өөрийнх нь даралгаар урсган эмнэлгийг хэрэгцээний усаар хангаж байна.

Эмнэлгийн гадна ариутгах татуургын шугам нь төвийн ариутгах татуургын шугамд холбогдсон учир бохир усны биологийн цэвэрлэх байгууламжийг одоогоор ашиглаагүй байна.

Тус төв нь цахилгаан хангамжийн ХТП-1109 дугаартай 10/04 кВ-ын 2*630 кВа чадалтай дэд станцын 0.4 кВ-ын хуваарилах байгууламж, 67, 120 кВа чадалтай 2 цахилгаан дизель генератортай байна.

Эмнэлгийн барилгуудыг бие даасан халаалтын зуухны газраас дулаанаар хангадаг бөгөөд төвлөрсөн дулааны хангамжийн шугам сүлжээнд холбогдоогүй байна.

Халаалтын зуухны газарт нийт 6 зуух ашиглагдаж байгаа бөгөөд БЗУИ-100 маркийн 2 зуух, ЭХУЗХ-ШГ-1000 маркийн тус бүр 1000 кВт хүчин чадалтай 2 зуух, нийт 4 зуухыг халаалтад, НРЖ-27 маркийн 1, ЭХУЗХ-ШГ-400 маркийн 1 зуух, нийт 2 зуухыг хэрэгцээний халуун усыг халаахад зориулан ашиглаж байна.

ЭХУЗХ-ШГ-1000 маркийн 2 зуух болон ЭХУЗХ-ШГ-400 маркийн маркийн 1 зуухыг 2022 онд шинээр угсарч суурилуулсан байна.

Одоогийн байдлаар барилгуудын халаалтыг зуухнаас шууд буюу дулааны хангамжийн хамааралтай системээр /зөвхөн 1 хэлхээтэй/, хэрэгцээний халуун усыг ялтсан дулаан солилцуур бүхий системээр дамжуулан хангаж байна.

2015-2022 онуудад А блок -Төв байрны гадна тал, дээврийн их засвар, халаах хэрэгслэл, шугам сүлжээний иж бүрэн их засвар, төв байрны 1 дүгээр давхарын /асрамжийн 2 дугаар клиник/ хана, таазны иж бүрэн засвар, шалны хэсэгчлэсэн засвар, 160 ортой эмнэлгийн барилгын халаалтын шугам сүлжээний иж бүрэн их засвар, тус эмнэлгийн барилгын лабораторийн хэсэгт цахилгаан, цэвэр, бохир ус, халаалт, халуун усны шугам сүлжээний иж бүрэн их засвар, 160 ортой эмнэлгийн барилгын гадна тал, 1 дүгээр давхар /Сэтгэцийн эмгэг судлалын 3 дугаар клиник/, 2, 3 дугаар давхар /Сэтгэцийн эмгэг судлалын 4, 5, 6 дугаар клиник, Шүүхийн сэтгэцийн

эмгэг судлалын клиник/, В блок- Асрамжийн тасгийн хана, тааз, шалны их засвар, соёлын танхимын дээврийн их засвар, уурын зуухны барилгын дээврийн их засвар, зуухны яндан, зууханд БЗУИ-100 тогоо 2 ширхэг, НР-27 тогоо 1 ширхэг, ШГ-100С кВт-ын тогоо 2 ширхэг, ШГ-100 кВт-ын тогоо 1 ширхэгийг шинээр суурилуулсан, мөн инженер техник, ажилчдын өрөө, насосны цехийн өрөөнүүдэд дотор заслалыг иж бүрэн их засварыг тус тус хийж гүйцэтгэсэн байна.

Мэргэжлийн хяналтын байгууллагын /хуучин нэрээр/ холбогдох хяналтын чиглэлийн улсын /ахлах/ байцаагчид 2000-2019 онуудад тус төвийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж, халаалтын зуух, яндан ийн ашиглалтын төлөв байдал, эмнэлгийн үйл ажиллагаа, халаалтын зуухны байр аль орчинд нөлөөлөх байдал, халаалтын зуухны ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, үнд, цэвэр усны чанар, аюулгүй байдал, хэсгийн цэвэрлэх байгууламжийн бохир усны цэвэршилт зэргийг хамруулан 15 удаа үзлэг шалгалтыг хийж 10 дүгнэлт, 4 албан шаардлага, халаалтын зуухны үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох тухай 1 акт үйлдэн хүргүүлж ажилласан байна.

Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газраас 2021-2023 онуудад тус төвийн А блок-Төв байр, Б блок-160 ортой эмнэлгийн барилга, В блок-Сэтгэц нийгмийн сэрвээн засах тасгийн барилга, В блок-Асрамжийн тасгийн барилга, уурын зуухны барилга, соёлын танхим, агуулахын барилга, угаалгын барилга зэрэг нийт 8 барилгыг паспортжуулж паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт гаргасан байна.

Үзлэг шалгалт хийх үеийн нөхцөл байдал:

Газар, геодези, зураг зүйн хяналтын чиглэлээр:

1. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны дүгнэлтгүй байгаа нь Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5 дахь хэсгийг;

2. Гадна ариутгах татуургын шугам сүлжээний ажлын гүйцэтгэлийн зураглалыг холбогдох мэдээллийн санд оруулаагүй байгаа нь Барилгын геодезийн ажил Б16Д 11-08-06-ийн 5.11 дэх заалтыг;

Хот төлөвлөлтийн хяналтын чиглэлээр:

1. Тус төвийн 160 ортой эмнэлгийн барилгаас 34 метр орчим зайд сургуулийн барилга, "Г" блок барилгаас 40-47 метр орчим зайд буюу эмнэлгийн эзэмшил газарт тулгаж гэр хорооллын суурьшил бүс үүссэн, байшин барилга баригдсан, эмнэлгийн гадна баруун, зүүн талын хашааны зарим хэсэгт эвдрэл гэл тэл үүссэн, онцгой объектын эзэмшил газрын хашааны зарим хэсгийг буулгаж сургууль

болон айл өрхийн орц, гарцын зориулалтаар ашиглан эмнэлгийн үйл ажиллагааг анд хүндрэл учруулж байгаа нь Хот байгуулалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1, Барилгын тухай хуулийн 12.1.1, "Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл аюулгүйн шаардлага" MNS 6392:2013 стандартын 4.1.1, "Эмнэлгийн зориулалттай барилга төлөвлөх" БНБД 31-22-21-ийн 4 дүгээр зүйлийг;

2. Тус төвийн цогцолборын гадна зам талбайн зарим хэсэгт хагацал, эвдрэл үүссэн байгаа нь Барилгын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.7 дэх заалтыг;

3. А блок -Төв байрны 2 дугаар давхрын галын шатыг зориулалтын дагуу байршуулаагүй, нэгдүгээр давхрын 104-106 дугаар өрөөний зориулалт, төлөвлөлтийг өөрчилсөн байгаа нь Барилгын тухай хуулийн 12.1.1, 46.4 дэх заалтуудыг;

4. Б блок буюу 160 ортой эмнэлгийн барилгын нэг оронд ноогдох тал байр хангалтгүй, ус зайлуулах системгүй, гал тогоо, конторын барилгын зоорийн давхрын ариун цэврийн өрөө нь агааржуулалтын системгүй, А блок буюу төв байр, Б блок буюу 160 ортой эмнэлэг, гал тогоо, эмийн сангийн барилгууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу зам, ариун цэврийн өрөөгүй байгаа нь Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6, 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.6, 15 дугаар зүйл, "Эмнэлгийн зориулалттай барилга төлөвлөх" БНБД 31-22-21-ийн 5 дугаар зүйлүүдийг;

Барилгын техникийн хяналтын чиглэлээр:

1. А блок- Төв байрны угсармал төмөр бетон хучилтуудын зарим хэсэг хэв гажилтанд орж хотойсон, төв барилга, жигүүрүүдийн даацын тоосгон ханануудын уулзвар хэсгээр өндрийн дагуу нилэнхүйдээ ан цав, хагаралтай, 2, 3 дугаар давхрын мозайкан шаланд суулт, хэв гажилт их хэмжээгээр үүссэн, хөндлөн хагаралуудтай, зарим хэсэгт эвдэрсэн байгаа нь Барилгын тухай хуулийн 46.1.3 дахь заалт, Барилга байгууламжийн ашиглалтын дүрмийн 3.3 дахь заалтыг;

2. Төв байрны 1 дүгээр давхрын буюу сэтгэцийн эмгэг судлалын 2 дугаар клиникийн хучилтын заадсын чигжээс шавардлага унаж зай завсар гарсан, модон шалыг хэсэгчлэн сольсон боловч зарим хэсэг хэв гажилтанд орж хотойсон, шалны зургийн хэсэгт суулт үүссэн, хөдөлгөөнтэй, модон шал зай завсар ихтэй, будаг нь хуурсан байгаа нь Барилгын тухай хуулийн 46.1.1 дэх заалт, Барилга байгууламжийн ашиглалтын дүрмийн 3.7 дахь заалтыг;

3. Төв байрны модон цонхнуудыг хуванцар хүрээ бүхий вакуум цонх оор сольсон боловч цонхнуудыг технологийн дагуу угсарч суулгаагүй, ялангуяа 1 дүгээр

давхрын цонхнууд их хэмжээгээр цантаж хөлөрсөн, салхи сийгдэг, зарим цонх мөст хөн, цонхны амалгааны болон тавцангийн будаг хуурч унасан, модон тавцан өм: өрч муудсан, ашиглалтын хугацаанд шинэчилж солиогүй нь Барилгын тухай хуулийн 46.1.1 дэх заалт, Барилга байгууламжийн ашиглалтын дүрмийн 3.7 дахь заалтыг;

4. А блок-Төв байрны борооны ус зайлуулах зарим яндан цоргогүй байгаа аас гадаргуугийн ус буурь хөрс, сууринд нэвчих нөхцөлийг бүрдүүлсэн, хаявчийн ханын шавардлага зарим хэсэгт ховхорч унасан байгаа нь Барилгын тухай хуулийн 46.1.9 дэх заалтыг;

5. Тус төвийн Б блок буюу 160 ортой эмнэлгийн барилгын таазаар дулаан их хэмжээгээр алддаг, ханын будаг, шавардлага хуурч унасан, Шүүх сэтгэцийн элгэг судлалын клиникийн 3 дугаар давхрын тааз, ханын уулзвар хэсгээр нилэнхүй дээ цантдаг, хөгцөрч харласан, зарим хэсэгт таазны шохой хуурч ховхорсон, ариун цэврийн өрөөний хана хөгцөрч харласан, ханыг цоолж агааржуулалтын хуванцар хос пой гаргасан, дээврийн салхижуулалтын цонхнуудыг битүүлж тагласан байгаа нь Барилгын тухай хуулийн 46.1.1, 46.1.3, 46.1.9 дэх заалтууд, Барилга байгууламжийн ашиглалтын дүрмийн 3.3, 3.7 дахь заалтуудыг;

6. Б блокийн барилгын дээврийн хучлагын эмжээр төмрийг дагаж бороо, цасны ус барилгын хана руу их хэмжээгээр гоождог ул мөртэй байгаа нь Барилгын тухай хуулийн 46.1.3 дахь заалтыг;

7. Б блокийн барилгын дээвэр рүү гарах зориулалт бүхий төмөр шат тасарч: лга болсон, зөвхөн дээвэр дээрх хэсэг үлдсэн байгаа нь Барилгын тухай хуулийн 46.1.1 дэх, Барилга байгууламжийн ашиглалтын дүрмийн 3.3 заалтуудыг;

8. Гал тогоо, эмийн сангийн барилгын борооны ус зайлуулах яндан зоогийн давхрын /газартай нийлсэн хэсэг/ өндрийн зөрүүтэй хэсэгт байрладаг, гадаргуугийн ус буурь хөрс, сууринд нэвчих нөхцөл бүрдсэн, зоогийн давхрын шатны доорх хана чийгтэй, цантдаг, хурын ус нэвтэрдэг ул мөртэй, барилгын дотор хана, таазны будаг нилэнхүйдээ хуурсан байгаа нь Барилгын тухай хуулийн 46.1.1, дэх заалтыг;

9. В блок - Сэтгэц нийгмийн сэргээн засах тасгийн болон асрамжийн тасгийн барилгын цонх их цантдаг, өрөө тасалгаанууд чийг ихтэй, цонхны доод хэсгийн ханын шавардлага хагарч зай завсар гарсан, шалны хавтанцарууд зарим хэсэгт хагарсан байгаа нь Барилгын тухай хуулийн 46.1.9, 46.1.1 дэх заалтууд, Барилга байгууламжийн ашиглалтын дүрмийн 3.3, 3.7 дахь заалтуудыг;

10. Угаалгын барилгын зоорийн давхар устай, чийг удаан хугацаа аар хуримтлагдсанаас угсармал төмөр бетон хучилтын шавардлага, заадсын чиглээс шавардлага, будгийн хамт нилэнхүйдээ ховхорч унасан, хучилтын хавтангийн ажлын арматур ил гарсан, өрөө тасалгаануудын хана, тааз хөгцөрсөн, халтартаж шарласан нь Барилгын тухай хуулийн 46.1.3, 46.1.9 дэх заалтуудыг;

11. Уурын зуухны барилга хаяавчгүй, хурын ус барилгын буурь хөрс, суурьнд нэвчих нөхцөл бүрдсэн, барилгын хойд хэсгийн гадна тоосгон хананд өндрийн хэмжээгээр босоо болон налуу хагарал үүссэн, өрлөгийн тоосго зарим хэсэгт үйрсэн, гадна ханыг нүхэлж агааржуулалтын хоолой, ханыг буулгаж цонх гаргасан, зуухны дотор талд утаа тортог их хэмжээгээр тогтсон, тоос шороо ихтэй, дотор заслал муудаж өнгө үзэмжгүй болсон байгаа нь Барилгын тухай хуулийн 46.1.1, 46.1.3, 46.1.9 дэх заалтууд, Барилга байгууламжийн ашиглалтын дүрмийн 3.3 дахь заалтыг;

12. Г-блокийн барилгын зүүн хойд талын хананд хялгасан хагарлуудтай, борсны ус зайлуулах хуванцар хоолой хагарсан, тасарч унасан, хаяавчийн хамгаалалтын үеийн бетон бутарсан, хаяавчийн хана хялгасан хагаралтай байгаа нь Барилгын тухай хуулийн 46.1.1 дэх заалтыг;

13. Соёлын танхимын баруун талын цонхыг битүүлж хана өрсөн, хаяавчийн ханын шавардлага ховхорч унасан, барилгын дээврээс бороо, цасны ус нэвтлэн гоождог байсны улмаас модон хучилт норж зарим хэсэг нь өмхөрч муудсан, хучилтын банзыуд хөгцөрч харласан, дүүжин тааз хэв гажилтанд орсон байгаа нь Барилгын тухай хуулийн 46.1.9 дэх заалтыг;

14. Агуулахын барилга хаяавчгүй байгаа нь гадаргуугийн ус буурь хөрс, суурьнд нэвчих нөхцөл бүрдсэн, цонхнуудыг битүүлж тоосгоор хана өрсөн, төмөр хаалгануудын хаагдах, нээгдэх хэсэг зай завсар ихтэй, ханын шавардлага ховхорч унасан тоосгон өрлөг ил гарсан, тоосго үйрсэн байгаа нь Барилгын тухай хуулийн 46.1.3, 46.1.9 дэх заалтуудыг;

15. Нийт барилгуудын шатны талбай, марш элэгдсэн, зарим барилгуудын модон хаалга, цонхны далавчнууд хэв гажилтанд орсон, зай завсар ихтэй байгаа нь Барилгын тухай хуулийн 46.1.1 дэх заалтыг;

Барилга байгууламжийн техникийн хяналтын чиглэлээр:

1. Тус төвийн нийт барилгуудын гадна, дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж тэдгээрийн туслагч төхөөрөмжүүдэд 1983 оноос хойш их засвар, шинэчлэлийн ажлууд хийгдээгүй ээс

хуучран муудаж ашиглалтын шаардлага хангахгүй болсон байгаа нь "Барилгын тухай" хуулийн 46.1.4 дэх, "Барилга байгууламж инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг норм БНБД 13-104-20"-ын холбогдох заалтуудыг;

2. Гадна ус хангамжийн шугам сүлжээний хамгаалалтын зурваст айл өрхөд газар олгож, хашаа, байшин, гэр барьсан байгаа нь "Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай" хуулийн 8.1.6, 17.6 дахь заалтуудыг;

3. Нийт барилгуудын гадна ариутгах татуургын шугам сүлжээнд засвар шинэчлэлийн ажил хийгдээгүй олон жил ашигласнаас шугам сүлжээ хуучирч элэгдэж ашиглалтын үеийн хэвийн найдвартай ажиллагааг хангахгүй байгаа нь "Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай" хуулийн 14.2.1, 14.2.4, 15.1.5, 15.1.8 дахь заалтууд, "Ус хангамж, ариутгах татуургын системийн техник ашиглагчын дүрэм" "Барилга байгууламж инженерийн шугам сүлжээний засвар, ашиглагчын хугацааны жишиг норм БД 13-104-20"-ын холбогдох заалтуудыг;

4. Эмнэлэг болон зуухны барилга байгууламжийн цахилгаан хангамжийн тасралтгүй ажиллагааг хангахаар суурилагдсан 67 кВт чадалтай дизель генераторын чадал нь хүрэлцэхгүй, эмнэлгийн өөрийн хэрэгцээг бүрэн хангах боломжгүй байгаа нь Эрчим хүчний тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь, "Цахилгаан эрчим хүч хэрэглэгчийн цахилгаан хангамжийн найдваржилтын зэрэглэл тогтоох журам"-ийн 3.2 дахь заалтуудыг;

5. Эмнэлгийн барилга байгууламжууд /10 блок/ нь аянга хамгаалалтын төхөөрөмж системгүй, төлөвлөөгүй, хийгдээгүй байгаа нь Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтыг;

6. Барилгын дотор цахилгааны холболтын утас, кабелиуд ил задтай, гэмтэл ихтэй, ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааны шаардлагыг хангахгүй болсон байгаа нь Эрчим хүчний тухай хуулийн 30.1.3 дахь, "Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм"-ийн 1.8 дахь заалтуудыг; /А блокийн барилга/

7. Барилгын 0.4 кВ-ын үндсэн болон давхар дундын хуваарилах самбарууд ашиглалтын шаардлага хангахгүй, ашиглалтын хугацаанд их засвар шинэчлэлийн ажлыг хийж гүйцэтгээгүй нь Эрчим хүчний тухай хуулийн 30.1.3 дахь, Хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн техник ашиглалтын дүрэм"-ийн 1.2.2 дахь заалтуудыг; /А, Б блокийн барилга, уурын зуухны барилга, В блок асрамжийн тасгийн барилга/

8. Барилгын 0.4 кВ-ын үндсэн хуваарилах самбарын газардуулгын байгууламж нь шаардлага хангахгүй, мөн давхруудын хуваарилах самбарууд нь газардуулгын байгууламжид холбогдоогүй, эсэргүүцлийг тогтоосон хугацаанд хэмжээтэй хийлгэн, акт үйлдэн баталгаажуулаагүй байгаа нь Хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн техник ашиглалтын дүрэм"-ийн 2.7.1, 2.7.8, 2.7.9 дэх заалтыг; /А, Б блокийн барилга, угаалгын барилга, В блок асрамжийн тасгийн барилга /

9. Барилгын аянга хамгаалалтын гүйдэл зайлуулагч буюу дамжуулагчууд нь зэврэлттэй байгаа нь Хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн техник ашиглалтын дүрэм"-ийн 2.7.1, 2.7.5 дахь заалтыг; /Г блокийн барилга /

10. Халаалтын зуухны газарт хими ус цэвэрлэгээний тоног төхөөрөмжгүй гэс дулааны сүлжээ болон халаалтын системд боловсруулаагүй түүхий усыг ашиглаж байгаа нь "Дулаацуулгын зуухны техник ашиглалтын дүрэм"-ийн 3.5 дахь заалтыг

11. Халаалтын зуухнаас гарч буй үнс шааргыг цуглуулах сан, байгуул амж байхгүйгээс үнс шааргыг ил задгай асгаж байгаа нь "0,07 мПа-аас бага даралттай уурын ба 115С-аас доош температуртай ус халаах зуухыг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм"-ийн 4.22 дахь заалтыг;

12. Зууханд ажиллаж буй галч, машинистууд сургалтад хамрагдаагүй, мэргэжлийн үнэмлэхгүй байгаа нь "0,07 мПа-аас бага даралттай уурын ба 115С-аас доош температуртай ус халаах зуухыг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм"-ийн 8.6 дахь заалтыг;

13. Хэрэгцээний халуун усны ялтсан дулаан солилцуур зэв бохирдлын улмаас халах гадаргуу бохирдож бөглөрсөн, хэвийн ажиллагаа нь алдагдсан байгаа нь "Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 5 дахь хэсгийг;

14. Гадна дулааны худаг №1-ээс №2 хүртэлх ф219 мм-ийн голчтой 50 орчим метр урттай хос халаалтын шугам, хэрэгцээний халуун усны ф80 мм-ийн голчтой хэрэгцээний халуун усны шугам, ф125 мм-ийн голчтой цэвэр усны шугамыг 2013 онд шинэчлэн сольсон боловч барилгуудын бусад тус бүр 800 метр урттай ф32-200 мм-ийн голчтой гадна халаалт, хэрэгцээний халуун хүйтэн усны шугамыг ашиглаж эхэлснээс хойшхи хугацаанд их засвар, шинэчлэлийн ажил хийгдээгүйгээс ихээхэн хуучирч муудсан байгаа нь "Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 5 дахь хэсгийг;

15. Барилгын дотор халаалтын систем, шугам сүлжээ, халаах хэрэгслүүдэд /2019 онд А блок-Төв байр, 2020 онд Б блок-160 ортой эмнэлгийн барилгаас бусад барилгын/ анх ашиглалтад оноос хойш бүрэн хэмжээний их засвар,

шинэчлэлийн ажил хийгдээгүй, шугам сүлжээ хуучирч муудсан, ашиглалтын шаардлага хангахгүй болсон нь "Барилга, байгууламж инженерийн шугам сүлжээ: ний засвар, ашиглалтын жишиг хугацаа" БД13-104-20 дүрмийн холбогдох заалтыг;

16. Барилга нь агаар сэлгэлтийн системгүй, бохир агаар, ийг хуримтлагдсанаас хүний эрүүл мэнд, барилга байгууламжид сөргөөр нөлөөлж байгаа нь "Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм"-ийн 3, 4 дүгээр хэсгийг; /Г блок 220 ортой өргөтгөл барилгаас бусад бүх барилга/

17. Б блокийн барилгын агаар сэлгэлтийн системийн хэвийн ажиллагаа алдагдсан, заал танхим болон гал тогооны хэсгүүдэд механик агааржуулалтын систем анх суурилагдсан боловч агаар сэлгэлтийн тоног төхөөрөмж, агаар үлээх сэнс эв, эрч ажиллагаагүй болсон, бохир агаар, чийг хуримтлагдсанаас хүний эрүүл мэнд, барилга байгууламжид сөргөөр нөлөөлж байгаа нь "Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм"-ийн 3, 4 дүгээр хэсгийг тус тус зөрчиж байна.

Дээрх байдлыг үндэслэн дүгнэлт болгох нь:

1. Сэтгэцийн эмгэг судлалын үндэсний төв нь газар эзэмших эрхийн гэрчилгээ, гэрээтэй, газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдсэн газрын хэмжээ, байршил, зориулалтыг өөрчлөөгүй, харин газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэж дүгнэлт гаргуулж дүгнэлтийг хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллаагүй байна.

2. Төвийн барилга байгууламж буюу онцгой объектоос 34-47 метр орчим зай, гэр хорооллын суурьшлын бүс үүсч байшин барилга баригдсан, онцгой объектын эзэмшил газрын хашааны зарим хэсгийг буулгаж сургууль, айл өрхийн орц, гагцын зориулалтаар ашиглаж байгаа нь эмнэлгийн үйл ажиллагаа болон иргэд, сурагчдад эрсдэл үүсэх, эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах эрх зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

3. Тус төвийн цогцолборын гадна зам талбайн зарим хэсэгт эвдрэл, хагарал үүссэн, А блок-Төв байрны 2 дугаар давхрын галын шатыг зориулалтын дагуу байршуулаагүй, нэгдүгээр давхрын 104-106 дугаар өрөөний зориулалт, төлөвлөггийг өөрчилсөн, Б блок буюу 160 ортой өвчтөний эмнэлгийн нэг оронд ноогдох талбай хангалтгүй, 160 ортой эмнэлгийн барилга нь ус зайлуулах системгүй, төв байр гал тогоо, эмийн сангийн барилга, 160 ортой эмнэлгийн барилгад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу зам, ариун цэврийн өрөөгүй байгаа нь хууль тогтоомж, барилгын норм ба дүрэмд заасан шаардлагуудыг хангахгүй байна.

4. Тус төвд "Сэтгэцийн эмгэг судлалын төв"-ийн өргөтгөлийн барилгын ажлын зураг (2007 он), А корпусын хэмжилтийн зураг (2013 он), Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв засварын ажлын зураг (2014 он), 160 ортой эмнэлгийн засварын ажлын зураг (2014 он), 160 ортой эмнэлгийн баруун жигүүрийн засварын ажлын зураг (2014 он), Лабораторийн засварын ажил (2014 он), Асрамжийн тасгийн нийтийн байрны засварын ажлын зураг төсөл (2016 он), 160 ортой эмнэлгийн А блок баруун жигүүрийн засварын ажлын зураг (2019 он), "Угаалгын барилга"-ын гадна ханын засварын ажлын зураг төсөл (2020 он), уурын зуухны барилгын засвар (2020 он) ажлын зураг төсөлүүд хадгалагдаж байгаа боловч барилгуудын иж бүрэн зураг төсөл, барилгын архитектурын хэсэг, ерөнхий төлөвлөгөөний хэсгийн ажлын зураг төслүүд байхгүй байна.

5. А блок-Төв байрыг эмнэлэг, үйлчилгээний зориулалтаар ашиглахаар анх төлөвлөөгүй, газар хөдлөлтийн эсрэг арга хэмжээ авагдаагүй баригдсан, барилгын угсармал төмөр бетон хучилтуудын зарим хэсэг хотойсон, 2, 3 дугаар давхрын шаланд хэв гажилт, суулт үүссэн, даацын тоосгон ханануудын уулзвар хэсгээр анцатай байгаа нь ашиглалтын үеийн аюулгүй байдлыг хангахгүй байна.

7. Б блок буюу 160 ортой эмнэлгийн барилгын 1, 2, 3 дугаар давхар болон лабораторийн хэсэг, В блок-сэтгэц нийгмийн сэргээн засах тасаг, асрамжийн тасгийн дотор хана, таазны иж бүрэн их засварыг хийж гүйцэтгэсэн боловч чийг ихтэй, дээврийн хучилтын ирмэгийн төмрийг дагаж хурын ус гоождог, барилгын таагаар дулаан их хэмжээгээр алддаг, Шүүх сэтгэцийн эмгэг судлалын клиникийн 3 дугаар давхрын өвчтөний өрөөнүүд болон ариун цэврийн өрөөний хана, тааз, ханын уулзвар хэсгээр нилэнхүйдээ цантдаг, хөгцөрч харласан, В блокийн барилгын шалны керемик хавтанцарууд зарим хэсэгт хагарсан байгаа нь ашиглалтын явцад өвчтөнүүдийн эрүүл мэндэд аюул учруулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

8. Гал тогоо, эмийн сангийн барилгын зоорийн давхрын /газартай нийлсэн хэсэг/ шатны доорх хана чийгтэй, норсон, цантсан хурын ус нэвтэрдэг ул мөртэй байна.

9. Угаалгын барилгын зоорийн давхар устай, чийг удаан хугацаагаар хуримтлагдсанаас угсармал төмөр бетон хучилтын заадсын чигжээс шавардлага, будгийн хамт нилэнхүйдээ ховхорч унасан, хучилтын хавтангийн ажлын арматурыл гарсан, зэвэрсэн байгаа нь хийц бүтээцийн бат бэх, тогтворт байдлыг алдагдуулах нөхцөлийг бүрдүүлж байна..

10. Уурын зуухны барилгын хойд хэсгийн гадна тоосгон хананд өндрийн хэмжээгээр босоо болон налуу хагарал үүссэн, өрлөгийн тоосго зарим хэсэгт үйрсэн, гадна ханыг нүхэлж агааржуулалтын хоолой, ханыг буулгаж цонх гаргасан, зуухны дотор талд утаа тортог тогтсон, тоос ихтэй барилгын дотор тал өнгө үзэмжгүй муудсан байгаа нь газар хөдлөлтийг тэсвэрлэх чадвар болон ашиглалтын үед эмнэлгийн үндсэн үйл ажиллагааг алдагдуулах, ажиллагсдын эрүүл мэнд, амь нас, хүрээлэн буй орчинд аюул, хохирол учруулж болзошгүй байна.

11. Г блокийн барилгын зүүн хойд талын хананд хялгасан хагарлуудтай, борооны ус зайлуулах хуванцар хоолой хагарсан, тасарч унасан, хаявчийн хамгаалалтын үеийн бетон үйрсэн, бетоны хайрга суларсан, хаявчийн хананд хялгасан хагарал үүссэн байгаа нь ашиглалтын үед тавигдах техникийн шаардлыг хангахгүй байна.

12. Нийт барилгуудын / Г блок -220 өвчтөний ортой өргөтгөл барилга, галтгоо, эмийн сангийн барилгаас бусад/ хуванцар хүрээ бүхий вакуум цонхнуудыг технологийн дагуу угсарч суулгаагүй, цонхнууд их хэмжээгээр цантаж хөлөрсөн, салхисийгдэг, зарим цонх мөстсөн, цонхны амалгаа, тавцангийн будаг хуурч унасан байгаа нь ашиглалтын үеийн эрүүл, аюулгүй байх нөхцөл, шаардлагыг хангахгүй байна.

13. Агуулахын барилга хаявчгүй, цонхнуудыг битүүлж хана өрсөн, төмөр хаалгануудын хаагдах, нээгдэх хэсэг зай завсар ихтэй, ханын шавардлага ховорч унасан тоосгон өрлөг ил гарсан, тоосго үйрч өгөршсөн байгаа нь газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг бууруулсан байна.

14. Барилгыг ашиглаж эхэлсэн үеэс хойш одоог хүртэл сантехникийн шугам сүлжээнд томоохон шинэчлэл, их засварын ажлууд хийгдээгүй байгаа тул шугам сүлжээний хэвийн ажиллагааг хангуулах иж бүрэн засвар, шинэчлэлийн ажлыг хийж гүйцэтгэх шаардлагатай.

15. Сантехникийн шугам сүлжээг их засвар шинэчлэл хийх хугацаанаас илүү хугацаагаар ашиглаж байгаа нь ашиглалтын найдвартай аюулгүй ажиллагааг хангахгүй байгаа тул хэсэгчилсэн болон иж бүрэн засвар, шинэчлэлийн ажлыг хийж гүйцэтгэх шаардлагатай.

16. А блок-Төв байр, В блок -Асрамжийн тасгийн барилгын 0.4 кВ-ын үндсэн болон давхар дундын хуваарилах самбарууд, цахилгааны холболтын дамжуулагч, утас, кабелиуд хуучирч муудсан, их засварын ажил хийгдээгүйгээс ашиглалтын үеийн шаардлага хангахгүй болж цахилгаан эрчим хүчний саатал, тоног төхөөрөмжийн

гэмтэл үүсэх ч ашиглалтын үеийн хэвийн найдвартай ажиллагааг алдагдуулах нөхцөлийг бий болгож байна.

17. Б блок -160 ортой эмнэлгийн барилгын 0.4 кВ-ын үндсэн хуваарилах, даххар дундын хуваарилах самбарууд нь ашиглалтын үеийн шаардлага хангаггүй, газардуулгын байгууламжид холбогдоогүй байгаа нь цахилгаан эрчим хүчний саатал, тоног төхөөрөмжийн гэмтэл үүсч ашиглалтын үеийн хэвийн найдвартай ажиллагааг алдагдуулах нөхцөлийг бий болгож байна.

18. Уурын зуухны барилгын 0.4 кВ-ын үндсэн хуваарилах самбарууд, аялга хамгаалалтын төхөөрөмж системгүй, төлөвлөөгүй, хийгдээгүй ашиглалтын үеийн шаардлага хангахгүй байгаа нь цахилгаан эрчим хүчний саатал, тоног төхөөрөмжийн гэмтэл үүсч ашиглалтын үеийн хэвийн найдвартай ажиллагааг алдагдуулах нөхцөлийг бий болгож байна.

19. Тус төвийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг хийж гэж, дүгнэлтэд заагдсан ажлуудыг тухай бүр хийж гүйцэтгэх нь зүйтэй.

20. Гадна ариутгах татуургын шугам сүлжээний ажлын гүйцэтгэлийн зураглалыг, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд бүртгэгдсэн объектуудыг холбогдох мэдээллийн санд оруулах хэрэгтэй.

21. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд тавигдах шаардлагын дагуу зай хэмжээг хангуулах, эмнэлгийн эдэлбэр газрыг сургууль, айл өрхийн орц, гагцын зориулалтаар ашиглуулахгүй байх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй.

22. Тус төвд Зураг төсөл, хот байгуулалтын үндэсний төвийн "Өргөө нүс" -д боловсруулсан уурын зуухны барилгын архитектурын тайлбар бичиг /И-001- -БА шифртэй/, барилгын бүтээцийн хэсгийн /И-001-4/ББ шифртэй/ иж бүрэн зураг төсөл, "Илч нүүс"-д боловсруулсан гадна дулаан хангамж, гадна усан хангамж, резервуар 100 м³, худгийн байгуулалт, огтлол, тоног төхөөрөмжийн байгуулалтын зураг төсөл, барилгуудын буурь хөрсний судалгааны дүгнэлт хадгалагдаж байгаа ба А блок Төв байранд хэмжилтийн зураг төслийг боловсруулж, барилгуудын хувийн хэргийг хөтөлж, 2014 оноос хойш хийгдсэн засварын ажлыг боловсруулсан зураг төслөөр хийж гүйцэтгэсэн байна.

23. Шалгалтын дүнгээр газар хөдлөлтийн эсрэг арга хэмжээ авагдаагүй баригдсан, барилгын хийц бүтээцийн даац хүлээн авах чадвар буурсан, хэв гажилт, суулт үүссэн А блок -Төв байр, уурын зуухны барилга, агуулахын барилгыг хүчиггэн

бэхлэх, эсхүл буулгаж шинээр барих ажлын тооцоо судалгааг хийж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцоолж эмнэлгийн үндсэн үйл ажиллагаа болон ажиллагсад, өвчтөнүүдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллах, эмчлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй.

24. Б блок буюу 160 ортой эмнэлгийн барилга, В блок-сэтгэц нийгмийн сэрвээн засах тасаг, асрамжийн тасаг, гал тогоо, эмийн сангийн барилга, угаалгын барилга, соёлын танхим, Г блокийн барилгад илэрсэн эвдрэл, гэмтлийг бүрэн арилгаж засварлах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, техникийн үзлэг, үйлчилгээ, засварын ажлыг тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэн, ашиглалтын үеийн аюулгүй байдлыг хангаж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх нь зүйтэй.

25. Халаалтын зуухны газарт хими ус цэвэрлэгээний тоног төхөөрөмж суурилуулж дулааны сүлжээ болон халаалтын системийг боловсруулсан агаар тэжээх, халаалтын зуухнаас гарч буй үнс шааргыг цуглуулах сан, байгууламж шинээр барих, зууханд ажиллаж буй галч, машинистуудыг мэргэжлийн сургалтад хамруулж үнэмлэхжүүлэх, хэрэгцээний халуун усны ялтсан дулаан солилцуурын зөв бохирдлыг цэвэрлэж хэвийн ажиллагаанд оруулах нь зүйтэй.

26. Цаашид барилгуудын дулаан хангамжийг зуухнаас хангах болон халаалтын системийг хамааралгүй схемд /ялтсан дулаан солилцуур бүхий халаалтын цогц төхөөрөмж/ шилжүүлэх, эсвэл төвлөрсөн дулаан хангамжид холбох асуудлыг зөвхөн төсөл, тооцоо, судалгааны үндсэн дээр мэргэжлийн байгууллагад хандаж шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.

27. Барилгуудын гадна халаалт, хэрэгцээний халуун, хүйтэн усны тус бүр 800 метр урттай ф32-200 мм-ийн голчтой шугам сүлжээний иж бүрэн их засвар, шинэчлэлийн ажлыг хийж гүйцэтгэх, барилгуудын дулааны узелиудыг холигч нассны узелээр шинэчлэн солих нь зүйтэй.

28. Барилгын дотор халаалтын систем, шугам сүлжээ, халаах хэрэгслүүдэл, иж бүрэн их засвар, шинэчлэлийн ажлыг хийж гүйцэтгэх, агаар сэлгэлтийн системийг шинээр төлөвлөж угсарч суурилуулах зэргээр халаалт, агаар сэлгэлтийн ажиллагааны хэвийн найдвартай ажиллагааг хангуулах нь зүйтэй байна. /Нийт барилгууд/

29. Барилгын цахилгааны шугам сүлжээ, тоног төхөөрөмжүүдийг ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааны шаардлагуудыг хангуулахад чиглэгдсэн их засвар, шинэчлэлтийн ажлуудыг батлагдсан ажлын зураг төсөл, тооцоо судалгааны үндсэн дээр тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх арга хэмжээг

авч ашиглалтын үеийн найдвартай ажиллагааг хангаж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх нь зүйтэй.

30. Цэвэр ус хангамжийн шугам сүлжээнд холбогдох байгууллагаар хамгаалалтын зурвас тогтоолгох ажлыг хийж гүйцэтгүүлэх нь зүйтэй.

31. Цэвэр ус хангамжийн шугам сүлжээний хамгаалалтын зурваст баригдсан барилга байгууламж, айл өрхийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

32. Ус хангамжийн төвлөрсөн систем болон биеэ даасан системийн ал нь ашиглалтын үед найдвартай, аюулгүй ажиллагааны хувьд үр дүнтэй талаар тохцоо судалгаа хийж, техникийн шийдэл гаргах нь зүйтэй.

Улсын /ахлах/ байцаагчийн гаргасан эрх зүйн баримт бичиг дүгнэлтийг эс зөвшөөрвөл Монгол Улсын "Төрийн хяналт шалгалтын тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

Энэхүү дүгнэлтэд тус төвийн барилга байгууламжуудын мэдээллийг хүснэгтээр гаргаж, барилгуудын эвдрэл гэмтлийн 4 хуудас зургийг хавсаргав.

БАРИЛГЫН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Н.ГАНЧИМЭГ

БАРИЛГЫН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Д. ГАНЧИМЭГ

ГАЗАР, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Д.БЯМБАДУЛАМ

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТЕХНИКИЙН
ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Б.МӨНХТӨВШИН

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТЕХНИКИЙН
ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Б.МӨНХСАЙХАН



БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТЕХНИКИЙН
ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Б.ОРХЭМБАЯР



ДҮГНЭЛТТЭЙ ТАНИЛЦАЖ ХҮЛЭЭН АВСАН:

СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ


В.БАЯРМАА

Б.Агдара - 2

4

Б.Армат

**ҮЭЛЭГ ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
БАРИЛГУУДЫН МЭДЭЭЛЛИЙН ХҮСНЭГТ**





Д/Д	Объектын нэр	Ашиг- лал- танд орсон он	Барилгын давхар, хэлбэр	Хэмжээ /м/		Үндсэн бүтээцийн шийдэл					Паспортжуулант хийсэн он, дүгнэлт
				урт	өргөн	суурь	гадна хана	хучилт	дээвэр, дээврийн хучлага		
1	А блок-Төв байр	1963	2 ба 3 давхар, /зоорьтой/ Ш хэлбэртэй	80.2	30.2	чулуут бетон	тоосго	уссармал төмөр бетон	шувуу нуруу бүхий хар цаасан хучлагатай		2022 он, хучигтэх шаардлагатай.
2	Б блок-160 ортой эмнэлгийн барилга	1982	3 давхар, Г хэлбэртэй	114	23	бетон	тоосго	уссармал төмөр бетон	хар цаасан хучлагатай		2023 он, хучигтэх шаардлагатай.
3	Гал тогоо, эмийн сангийн барилга	1985	2 ба 3 давхар, зоорьтой, тэгш өнцөгт хэлбэртэй	28	14	бетон	тоосго	уссармал төмөр бетон	хар цаасан хучлагатай		2023 он, хучигтэх шаардлагатай.
4	Угаалгын барилга	1967	1 давхар, тэгш өнцөгт хэлбэртэй	19	12	бетон	тоосго	уссармал төмөр бетон	шувуу нуруу бүхий хар цаасан хучлагатай		2021 он, хучигтэн ашиглах боломжтой.
5	Соёлын танхим	1976	1 давхар, тэгш өнцөгт хэлбэртэй	20	10	бетон	тоосго	модон	шувуу нуруу бүхий төмөр хучлагатай		2021 он, хучигтэх шаардлагатай.
6	Агуулахын барилга	1967	1 давхар, тэгш өнцөгт хэлбэртэй	30	10	чулуут бетон	тоосго	уссармал төмөр бетон хавиргат хавтан	хар цаасан хучлагатай		2021 он, газар хөдлөлтөд тэсвэргүй.
7	В блок-Сэтгэц нийгмийн сэргээн засах тасгийн барилга	2004	1 давхар, тэгш өнцөгт хэлбэртэй	40	13	бетон	модон	модон	шувуу нуруу бүхий төмөр хучлагатай		2021 он, газар хөдлөлтөд тэсвэртэй.

8	В блок- Асрамжийн тасаг	2007	1 давхар, тэгш өнцөгт хэлбэртэй	40	13	бетон	модон	модон	шувуу нуруу бүхий төмөр хучлагатай	2022 он, газар хөдлөлтөд тэсвэртэй.	
9	Г блок- 220 өвчтөний ортой өргөтгөл барилга /4 блок/	2014	2 ба 3 давхар, тэгш өнцөгт хэлбэртэй	73.9	60.6	цутгамал баганан болон шугаман	цтб арагт бүтээц		хар цаасан хучлагатай	-	
10	Уурын зуухны барилга	1974	2 давхар, тэгш өнцөгт хэлбэртэй	54	10	угсармал төмөр бетон хавтан	тоосго	угсармал төмөр бетон хавиргат хавтан	хар цаасан хучлагатай	2021, газар хөдлөлтөд аюултай.	
11	200 м³-ийн багтаамжтай усан сан	1970				цутгамал төмөр бетон					-
12	Бага оврын цэвэрлэх байгууламж	2014									-






Улсын ахлах шүүхийн
 02-00-01/00-1/00-1/00-1
 дугаартай хавсралт-2

А блокийн барилгад үүссэн эвдрэл гэмтэл:









Б блокийн барилгад үүссэн эвдрэл гэмтэл:










Улаалтын барилгын эвдрэл гэмтлийн байдал







Гал тогоо, агуулах, лабораторийн барилгад үүссэн эвдрэл гэмтэл

Г-блокийн барилга






Уурын зуухны барилгад үүссэн эвдрэл гэмтэл





Улаан булангийн барилгын эвдрэл гэмтлийн байдал



В блокийн Асрамжийн тасгийн барилгын эвдрэл гэмтлийн байдал

